

ARTICLE

Академич Бямбын Ринчений романууд дахь аман зохиолын уламжлал

*Адилбишийн АМАРДАЛАЙ¹**Монгол Улс, Улаанбаатар,**Монгол Улсын Боловсролын Их Сургууль,**Багишийн сургууль, Монгол хэл, нийгмийн ухааны тэнхим**Email: amardalai@msue.edu.mn,**<https://orcid.org/0009-0008-0343-0125>***Received:** November 30, 2025 | **Accepted:** December 15, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг, нэрт соён гэгээрүүлэгч, академич Бямбын Ринчений 1965 онд хэвлэгдсэн “Заан Залуудай” роман нь Монголын төдийгүй Төв Азийн хүүрнэл зохиолын санд балар эртний хүний амьдралыг уран сайхны аргаар боловсруулан харуулсан анхны томоохон хэмжээний түүхэн-палеонтологийн бүтээл юм. Энэхүү өгүүлэлд уг романд туссан монгол ардын аман зохиолын баялаг уламжлал, түүнийг зохиолч хэрхэн уран сайхны аргаар дахин боловсруулж, дүрийн сэтгэлгээ болон хэл найруулгад шингээснийг иж бүрэн шинжлэн үзэхийг зорилоо. Б.Ринчен балар эртний хүний амьдрал, байгаль дэлхийгээ танин мэдэх гэсэн анхны оролдлого, хүй нэгдлийн нийгмийн дотоод харилцааг дүрслэхдээ монгол ардын аман зохиолын төрөл зүйлээс домог зүй, бөө мөргөлийн дуудлага, ерөөл, магтаал, хараал зүхлийн үг, зүйр цэцэн үг болон аман домгийн сэтгэлгээг чадварлаг ашигласан байдаг.

Судалгааны явцад бид зохиолын эх бичвэрт бичвэр судлалын шинжилгээ хийж, эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл нь аман зохиолын хэлбэрээр хэрхэн илэрч байгааг Монголын нэрт уран зохиол судлаачид болох С.Лувсанвандан, Х.Сампилдэндэв, Д.Цэдэв нарын зэрэг ахмад эрдэмтдийн эрдэм шинжилгээний бүтээлүүд, тэдгээрийн үзэл баримтлалтай холбон тайлбарлахыг хичээлээ. Эрдэмтэн зохиолч Б.Ринчен нь балар эрт цагийн хүний тухай түүхэн сэдэвт уран сайхны роман бичихдээ аман зохиолыг зөвхөн хэлбэрийн төдий бус, түүний утга агуулгыг гүн гүнзгий ашиглаж, хүн төрөлхтний оюун санааны хөгжлийн эхэн үеийн дүр төрхийг монгол хэлний баялаг сан, аман аялгууны онцлогтой сүлжсэн нь уг бүтээлийн гол үнэ цэн оршиж буй юм. “Заан Залуудай” романы хэл найруулга, дүр бүтээх арга барил нь монгол аман зохиолын язгуур шинжийг хадгалж, түүхэн балар эртний орчныг амилуулахад гол үүрэг гүйцэтгэсэн болохыг бид

¹ ©, Зохиогч, 2025

судалгаагаар нотолж байна. Эцэст нь, уг бүтээл нь шинжлэх ухааны баримтыг уран сайхны сэтгэлгээ, аман зохиолын уламжлалтай нэгтгэсэн Монголын уран зохиолын түүхнээ түүхэн сэдэвт романы хөгжлийг нэг шат ахиулсан үнэ цэнтэй, өвөрмөц бүтээл болохыг энэхүү өгүүллээр харуулахыг оролдлоо.

Түлхүүр үг: Эртний домог зүй, угсаатны зүйн дүрслэл, хүүрнэл зохиолын хэл, түүхэн сэтгэлгээ, бөө мөргөлийн зан үйл, археологийн олдвор

The Tradition of Oral Literature in the Novels of Academician Byambyn Rinchen

AMARDALAI Adilbish
Department of Mongolian Language and Social Sciences,
Teachers School
Mongolian National University of Education
Ulaanbaatar, Mongolia

Abstract: *The novel “Zaan Zaluudai”, published in 1965 by academician Byambyn Rinchen, a renowned enlightener and one of pioneers of modern Mongolian literature, is the first major historical-paleontological work in the literary heritage of Mongolia and Central Asia to artistically depict the life of prehistoric humans. This article aims to comprehensively analyze the rich traditions of Mongolian folklore reflected in the novel and how the author reworked them to integrate these traditions into the characters' mindsets and linguistic styles. In portraying the lives of prehistoric people, their initial attempts to understand the natural world, and the internal dynamics of primitive society, Rinchen B. masterfully employed ancient forms of oral literature, including mythology, shamanic invocations, blessings, curses, taboos, and the cognitive frameworks of oral legends.*

Throughout the research, we conducted a textual analysis of the original work, explaining how the prehistoric worldview is expressed through oral literary forms. This analysis is linked to the academic theories and concepts of prominent Mongolian literature scholars such as Luvsanvandan S, Sampildendeв Kh, and Tsedev D. The author utilized oral traditions not merely as a formal decoration but at a profound semantic level, weaving the early stages of human cognitive development with the rich vocabulary and dialectal characteristics of the Mongolian language, which constitutes the primary value of this work. Our study proves that the linguistic style and characterization methods of “Zaan Zaluudai” preserve the fundamental traits of Mongolian folklore and contribute greatly to visualizing the prehistoric historical environment to life. Finally, the article highlights that this work represents a unique genre of the Mongolian historical novel, successfully synthesizing scientific facts with artistic imagination and oral literary traditions.

Keywords: *Zaan Zaluudai, folklore, modern, oral legends, analysis, Mongolian historical novel*

Удиртгал

XX зууны монголын орчин үеийн уран зохиол хийгээд шинжлэх ухаан, соёл, хэл шинжлэл, угсаатны зүй судлал, сэтгүүл зүйн түүхэнд академич Б.Ринчен

(1905-1977) шиг олон талт мэдлэгтэй, гүн ухаанч, соён гэгээрүүлэгч бичгийн их хүмүүн ховор билээ. Тэрээр хэл шинжлэл, угсаатны зүй, аман зохиол, сэтгүүл зүй, орчуулга, түүхийн шинжлэх ухааны асар их мэдлэгээ уран сайхны сэтгэлгээтэй хослуулж, монгол хүүрнэл зохиол тэр дотроо монголын орчин үеийн роман бичлэгийн хөгжлийг нэг шат ахиулсан юм. Эрдэмтэн зохиолч Б.Ринчен монголын өнгөрсөн түүхийн бүхий л цаг үеийг хамруулсан роман бичихээр төлөвлөн өөртөө зорилго тавьж, хамгийн түрүүнд нь XIX сүүлч үеэс XX зууны дунд үеийн үйл амьдралыг харуулсан “Үүрийн туяа” гэх гурамсан романаа бичсэн юм. Үүний дараагаас өөрийн төлөвлөсний дагуу хамгийн эрт үйл явдлын тухай буюу монгол нутагт эрт балрын цагт амьдарч байсан хүмүүсийн тухай өгүүлэх “Заан Залуудай” хэмээх романыг бичсэн байдаг. Энэхүү өгүүлэлд түүний 1964 онд хэвлүүлж уншигчдын гарт хүрсэн уг роман дахь аман зохиолын уламжлалын талаар өгүүлэх болно.

Зохиогч “Заан Залуудай” хэмээх роман бичих болсон тухайгаа хэлэхдээ “Үүрийн туяаг бичин гүйцэх үес, надад нэгэн санаа төрж: түүх юүгээн бүтээгч ард түмнийхээ үе үеийн байдлаас нэг роман бичиж, эртнээс Үүрийн туяа хүртэл үргэлжилсэн нэгэн цуврал роман бичиж үзвэл зүгээр юм сан гэж бодогдлоо” (Ринчен, 1964: 13) гэж өөрийн бүтээлийн үүдэл санаагаа бичсэн байдаг. Түүний 1964 онд туурвисан “Заан Залуудай” роман нь Монголын төдийгүй дэлхийн уран зохиолд ховор тохиолдох балар эртний хүний амьдрал, хүн төрөлхтний үүсэл гарлын сэдвийг монгол нутгийн хөрсөн дээр амилуулсан хосгүй бүтээл юм.

Зохиолч Б.Ринчен энэхүү бүтээлээрээ монгол нутагт оршин тогтнож байсан балар эртний хүмүүсийн нийгмийн байгуулал, харилцааг дүрслэхдээ монгол ардын аман зохиолын асар баялаг уламжлалыг тулгуур багана болгон ашиглажээ. Эрдэмтэн судлаач Д.Цэнд Б.Ринчений бүтээл туурвилын онцлогийг тодорхойлохдоо: “түүний түүхэн зохиолд ардын аман зохиол, эртний уран зохиолын баялаг туршлага уламжлалыг өвлөн авч идээшүүлсэн онцлог, шинэ нөхцөлд шинэчлэлд өрнүүлж уламжлал шинэчлэлийн холбоог нягт зохилдуулж урлан туурвисан нь энэ сэдвийг судлахад баялаг хэрэглэгдэхүүн болж байна” (Цэнд, 2001: 44) хэмээн тэмдэглэсэн байдаг. Энэхүү үнэлэлт нь “Заан Залуудай” романы аман зохиолын уламжлалтай холбогдох язгуур шинжийг шууд илэрхийлж байна.

“Заан Залуудай” роман нь хүн төрөлхтний оюун санааны хөгжил, байгаль дэлхийг танин мэдэх эхэн үеийн оролдлогыг дүрсэлдгээрээ онцлогтой. Зохиолч балар эртний хүний сэтгэлгээг орчин үеийн хэлээр бус, харин аман зохиолын эртний хэлбэрүүд болох домог зүй, бөө мөргөлийн зан үйлийн үг хэллэгээр дамжуулан илэрхийлсэн нь судалгааны чухал асуудал болдог. Шүүмжлэгч, эрдэмтэн Ц.Хасбаатар Б.Ринчений хүүрнэл зохиолын хэлний талаар өгүүлэхдээ: “Ринчен гуайн бүтээл бүхэн нь монгол хэлний язгуур баялгийг сэргээн ашиглаж, мартагдсан аман соёлын өвийг орчин үеийн уншигчдад хүргэх амьд гүүр болдогт түүний бүтээлүүдийн амин чанар оршино” (Хасбаатар, 1979: 145) гэж онцолжээ.

Аман зохиол бол ард түмний түүхэн ой санамж, ертөнцийг үзэх үзлийн илэрхийлэл юм. “Заан Залуудай” романд аман зохиолын уламжлал нь зөвхөн эшлэл төдий бус, зохиолын баатруудын амьд хэл яриа, шүтлэг бишрэл, амьдрах ёс журам болон шингэсэн байдаг. Энэ тухай нэрт аман зохиол судлаач Х.Сампилдэндэв тэмдэглэхдээ: “Б.Ринчен “Заан Залуудай” романаараа монгол

аман зохиолын нэн эртний давхарга болох домог зүй, бөөгийн дуудлага, домын үгс нь хүн төрөлхтний сэтгэлгээний анхдагч хэрэглүүр байсныг уран сайхны аргаар нотлон харуулсан юм” (Сампилдэндэв, 1983: 218) гэжээ. Б.Ринчений бүтээлүүд дэх уламжлал, шинэчлэлийн асуудал нь ялангуяа “Заан Залуудай” нь монгол аман зохиолын хүүрнэл зүйн арга барилыг Европын романы сонгодог хэлбэртэй чадварлаг хослуулсан байдаг. Энэ нь зохиолыг улам ч үнэмшилтэй, баримтжуулсан шинжтэй болгодог.

Ер нь эрдэмтэн зохиолч Б.Ринчен бол бүхий бүтээлээ туурвихдаа үндэсний хэл соёл, түүх, аман зохиолын баялаг их хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр хэрэглэсэн нь харагддаг. Үүний нэгээхэн жишээ нь түүний “Нууцыг задруулсан захиа” зохиолоо бичихдээ олон жилийн өмнөх ардын дунд буй үгийг сонсож түүний утга санааг уйгагүй эрэн хайж байсны эцэст сая “Хүйсийн говийн домог”-т тулгуурлан бичсэн байдаг. Түүний зохиол бүтээл дэх ардын аман зохиолын нөлөө тусгалын тухай доктор С.Лувсанвандан хэлэхдээ “Б.Ринчен бол ардын зохиолч билээ. Тэр ардын билиг зүйгээс уран бүтээлийн эх сурвалж хэрэглэгдэхүүнийг олж мэддэг төдийгүй, бас өөрийн ардын хууч ярианы нэгэн гол дүр болжээ” (Аким, 1990: 28) гэж түүний уран бүтээл дэх ардын аман зохиолын уламжлал хийгээд түүний ардын дунд домог мэт тархсан хуучны ярианы тухай дүгнэлт хийсэн байдаг.

Ийнхүү академич Б.Ринчений “Заан Залуудай” роман дахь аман зохиолын уламжлалыг судлах нь монгол түүхэн романы урлах арга барил, хэл найруулга, үндэсний сэтгэлгээний онцлогийг гүнзгийрүүлэн танин мэдэхэд онол-арга зүйн чухал ач холбогдолтой юм. Бид энэхүү өгүүлэлдээ дээрх эрдэмтдийн дэвшүүлсэн үзэл санаанд тулгуурлан, зохиолын эх бичвэр дэх аман зохиолын элементүүдийг түүхэн бодит байдалтай хэрхэн уялдсаныг нарийвчлан шинжлэх болно.

Судалгааны арга, хэрэглэгдэхүүн: Энэхүү өгүүлэлд дараах аргуудыг аль болох бүтээлч байдлаар ашиглахыг оролдов. Үүнд:

Түүхэн-харьцуулсан шинжилгээний арга: Романд дүрслэгдсэн балар эртний үеийн үйл явдлыг монгол аман зохиолын домог зүйн давхаргатай харьцуулан шинжлэв.

Бичвэр судлалын арга (Textual Analysis): “Заан Залуудай” романы 1964 оны эх хэвлэлийн эх бичвэрт тулгуурлан, үг хэллэг, аман зохиолын төрөл зүйлүүдийг ялгаж авч үзэв.

Угсаатны зүйн тайлбарлах арга: Зохиолд гарч буй зан үйл, шүтлэг бишрэлийн элементүүдийг монгол угсаатны зүйн мэдлэгтэй холбон тайлбарлалаа.

“Заан залуудай” роман дахь аман зохиолын уламжлал

“Заан Залуудай” романы баатрууд болох хүй нэгдлийн хүмүүс байгаль дэлхийг амьдчилан үзэж, юмс үзэгдэл бүхнийг эзэн савдагтай хэмээн шүтдэг. Энэхүү домог зүйн сэтгэлгээ нь романы үйл явдал өрнөх үндсэн хөрс болдог. Зохиолч эртний хүмүүсийн аливаа эд өөрийн эзэнтэй тэдгээр зүйлс ямагт өөрийн эзэнтэй хамт байдаг буюу хүн ямар нэг шалтгаанаар үхсэний дараа эд зүйлс хамт байх гэсэн үзэл санааг зохиолдоо гаргасан байдаг. Энэ нь “Заан Залуудай” романы эхний хэсэгт голын эргээр өдөр тутмын хоол хүнсээ бэлтгэх үед гэнэт догшин хирс дайрч хэд хэдэн хүүхэд эмэгтэйчүүд тэргүүтэй хүмүүс нас барсны оршуулах

зан үйлээс харагдана.

Зохиолд гарч буй нь “Уулын энгэрт Оодойн заавраар эмэгтэйчүүд мод чулуугаар хэдэн нүх ухаад, өвгөн дархан нөгчигсдийн хувцсыг энд тэнд нь чулуун хутгаараа эсгэж, чарх гэдэг түүхий ширийг нойтонд нь хөлийнхөө шагайд хүртэл хумин тааруулж хатаасан шаахай гутлын зуузай хавьд бас эсгэж” (Ринчен, 1964: 13) хэмээн гарч буй нас барсан хүнийг дагуулж тавих эд өлгийн зүйлийг гэмтээж тавьдаг домог зүйн ёс одоо хэр ч бидний дунд байсаар байгаа уламжлал юм. Үүнийг зохиолч зөвхөн одоох үеийн бус энэ нутаг оронд амьдарч ирсэн монгол өвөг дээдсийн үлдээсэн ёс уламжлал гэдгийг харуулсан байна.

Мөн зохиолд тэнгэр газрыг аргадан залбирч буй хэсэгт:

Чоо-чоо-чоо! Сонсон хайрла
Өрх гэрт төрсөн Мангина нар
Өвөр энгэрт орших цаг боллоо!
Мах ясанд төрсөн Мангина нар
Манаас салан хагацлаа, та нар!
Хий бие биелэн одлоо, та нар
Хиншүү идээтэн боллоо, та нар!
Хилин дүрээ атаатандаа хандуулж,
Хишиг ээлээ халуундаа хайрла! (Ринчен, 1964: 14).

Энэ монгол ардын аман зохиолын шууд уламжлал гэдэг нь илэрхий харагдана. Учир нь энэ бол ардын аман зохиолын нэгэн төрөл хэмээн үздэг “Бөөгийн дуудлага”-ын хэм хэмнэлтэй шууд нийцэж байгаа бөгөөд хүй нэгдлийн хүн байгалийн хүчнээс хараат байсан сэтгэл зүйн бодит тусгал юм. Түүнчлэн тухайн үеийн хүний хувьд байгалийн давшгүй үзэгдэл болох зэрлэг амьтдын дээрх мэт дайралтыг нэг талаараа “Тэнгэр хилэгнэлээ” хэмээн үзэж, түүнийг тайвшруулахын тулд хийж буй зан үйл нь домог зүйн гүнзгий үндэстэйг харуулдаг.

Тэрчлэн “Монголын нууц товчоо”-ны 103-р бүлэгт Чингис хаан Мэргид аймгийн гэнэтийн довтолгооноос Хуагчин эмгэний сонорын хүчээр амь мэнд гарсандаа талархаж Бурхан Халдун уул дээр гарч өгүүлсэн хэсэгт:

“Солонго мэт сонсох
Соргог Хуагчины
Сонор хүчээр
Үен мэт үзэх
Үнэнч Хуагчины
Үзсэний ачаар
[Аюулт дайснаас
Амжин дутааж]
Бүтэн биеэ
Бүгэн нуугдаж” (Дамдинсүрэн, 2004: 55)

гэж гардаг бол “Заан Залуудай” романд

Солонго мэт
Сонсох тул,
Үсн мэт
Үзэх тул

бас л алсын үнэр хэдийн мэдэж, галын баруун зүг суусан хүнд анхааруулж

(Ринчен, 1964: 15-16) гэж мөн гардаг. Үүнийг зохиолч шууд Монголын нууц товчооноос хуулсан бус харин ардын аман зохиолын үг хэллэгийг орчин цагийн бичгийн зохиолд бүтээлчээр хувирган хэрэглэж зохиолын дүр хийгээд үйл явдлыг илүү тод дүрсэлж гэж болно. Мөн зохиолч романыхаа үг хэллэгийг ардын аман зохиол хийгээд ардын аман ярианы хэл рүү тэр дундаа туульсын хэллэгт ойртуулсан нь түүхэн балар эртний орчныг амилуулах гол хүчин зүйл болжээ. Зохиол доторх байгалийн дүрслэлүүд нь үлгэр, туульсын эхлэл шиг сүрлэг, хэмнэлтэй байдаг.

Унасан их дайд газартаа
Угаасан их далай усандаа
Амтат идээнийхээ дээжийг
Арван хуруугаараа өргөнөм
Өргөн их мөрөнд сад тавьж
Өндөр өвгөдийнхөө нутагт
Алс холын аян замаас
Амь мэнд буцаж ирсэндээ
Баярын магнай магнайж
Барьц идээгээ өргөнөм!

гэж усанд цацав (Ринчен, 1964: 97) гэсэн нь монгол ардын ерөөл, магтаалын дүрслэх арга барилыг санагдуулна. Мөн зохиолд хүмүүс хоорондоо харилцахдаа зүйр цэцэн үг, хэлц хэллэгийг ихээр ашигладаг. Энэ нь хүй нэгдлийн нийгмийн харилцааг илэрхийлэхдээ тухайн үеийн “ёс журам” нь аман зохиолын хэлбэрээр хадгалагдаж байсныг харуулдаг.

Эцэст нь “Заан Залуудай” роман дахь аман зохиолын уламжлал нь зөвхөн хэл ярианы түвшинд бус, баатруудын ертөнцийг үзэх үзэл, нийгмийн харилцаа, ёс заншлын гүнд нэвт шингэсэн байна. Б.Ринчен аман зохиолыг ашиглахдаа түүнийг хөлдүү, хөдөлгөөнгүй баримт биш, харин тухайн нийгмийн амьд харилцааны хэрэгсэл болгон хувиргаж чаджээ. Зохиолын эх бичвэрээс авсан эдгээр бодит эшлэлүүд нь “Заан Залуудай” романыг монгол аман соёлын “амьд музей” гэж нэрлэх бүрэн үндэстэйг харуулж байна.

Судалгааны үр дүн: Академич Б.Ринчений “Заан Залуудай” романы зах зухаас товч ажиглахад зохиолч балар эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний онцлогийг гаргахдаа аман зохиолын баялаг өв санг гол тулгуур болгосон байна. Байгаль дэлхийн юмс үзэгдлийг амьдчилан үзэх, хүний өдөр тутамд хэрэглэгдэг эд зүйлс болон уул усны эзэдтэй харилцах зан үйл нь романы үйл явдлыг хөдөлгөгч хүч болж байгаа нь харагдлаа.

Мөн романы дүрүүдийн харилцан яриа болон дотоод сэтгэлгээнд бөөгийн дуудлага, ардын домын үгсийг ашигласан нь хүй нэгдлийн нийгмийн дотоод зохион байгуулалт, шүтлэг бишрэлийн бодит дүр төрхийг илэрхийлж байна. Энэ нь зохиолыг зүгээр нэг адал явдалт бус, харин угсаатны зүйн гүнзгий агуулгатай түүхэн бүтээл болгож байна. Тэрчлэн зохиолч аман зохиолын хэл найруулгыг ашиглан балар эртний монгол нутаг дахь орчин ахуйг амилуулж чадсан байна.

Дүгнэлт

Академич Б.Ринчений “Заан Залуудай” роман нь Монголын түүхэн романы төрөл зүйлд хүй нэгдлийн үеийн сэдвийг аман зохиолын уламжлалтай нягт холбон туурвисан өвөрмөц, дахин давтагдашгүй бүтээл мөн болно. Зохиолч аман зохиолын баялаг санг зөвхөн хэлбэрийн төдий бус, харин балар эртний хүний оюун санаа, нийгмийн харилцааг нээх арга зүй болгон ашиглажээ.

Энэхүү бүтээл нь монголчуудын эртний өв соёл, аман билгийн уламжлал нь хэдэн мянган жилийн турш тасралтгүй үргэлжилж ирснийг уран сайхны аргаар баталсан соёл иргэншлийн том тайлал юм. Зохиолд туссан домог зүй, бөө мөргөл, зан үйлийн элементүүд нь балар эртний хүнийг өнөөгийн уншигчидтай ойлголцуулах оюуны гүүр болж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, “Заан Залуудай” роман нь Б.Ринчений эрдэмтэн хүний нарийн нягт судалгаа болон зохиолч хүний уран сайхны сэтгэмж хоёрын нэгдэл бөгөөд монгол аман зохиолын уламжлалыг орчин үеийн хүүрнэл зохиолын төрөлд хэрхэн чадварлаг шингээж болохын сонгодог жишээ болон үлдэж байна. Энэхүү бүтээл нь монгол үндэстний хэл, соёл, түүхэн ой санамжийг хадгалан үлдэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан билээ.

Ном зүй

- Аким, Г.** (1990). *Билгүүн номч Бямбын Ринчен*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Akim, G. Bilguun nomch Byambiin Rinchen. [Wise Scholar Byambyn Rinchen]. Ulaanbaatar: National Publishing House.1990.]
- Дамдинсүрэн, Ц.** (2004). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Damdinsüren, Ts. Mongolyn nuuts товчоо. [The Secret History of the Mongols]. Ulaanbaatar: Soyombo printing. 2004.]
- Ринчен, Б.** (1964). *Заан Залуудай*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Rinchen, B. Zaan Zaluudai. [A Novel of the Stone Age Clans]. Ulaanbaatar: National Publishing House. 1964.]
- Сампилдэндэв, Х.** (1983). *Орчин үеийн аман зохиолын зарим асуудал*. Улаанбаатар: Ардын боловсролын яамны хэвлэл. [Sampildendew, Kh. Orchin üeiin aман zokhioliin зарим асуудал. [Some Issues of Modern Oral Literature]. Ulaanbaatar: Ministry of People's Education Publishing House. 1983.]
- Хасбаатар, Ц.** (1979). *Реализмын тухай. Монголын утга зохиолд реализм хөгжсөн нь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Khasbaatar, Ts. Realizmiin tukhai. Mongoliin utга zokhiold realizm khögsön ni. [Realism: The Development of Realism in Mongolian Literature]. Ulaanbaatar: National Publishing House. 1979.]
- Цэнд, Д.** (2001). *Бямбын Ринчен. XX зууны монгол зохиолчид цуврал. №66*. Улаанбаатар: Бэмби сан. [Tsend, D. Byambiin Rinchen. XX zuunii mongol zokhiolchid tsuwрал. №66. [The 20th century Mongolian writers. (Byambyn Rinchen) No. 66]. Ulaanbaatar: Bembi san. 2001.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>